

“АВТОБУС-3” ОРОН НУТГИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН ТООЦООТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР
ТҮҮХЧИЛСЭН ЛАВЛАХ

2014 оны 11 дүгээр сарын 14

Улаанбаатар

ХОТ

Нэг. Байгууллагын түүх

“Автобус-3” компани нь анх Улаанбаатар хотын Ардын депутатуудын хурлын гүйцэтгэх захиргааны 1991 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 356 дугаар тогтоолоор Баянзүрх дүүргийн 8 дугаар хорооны нутагт дэвсгэрт хуучнаар “30 дугаар авто бааз”-ын суурин дээр байгуулагдсан бөгөөд 1997 оны 06 дугаар сарын сүүлчээр Сүхбаатар дүүргийн 2 дугаар хорооны нутаг дэвсгэр дэх “Автобус нэг” компанийн хуучин байранд шилжин байрлаж одоог хүртэл үйл ажиллагаа явуулж байна.

Байгууллагын зорилго

Иргэдэд нийтийн тээврийн үйлчилгээгээр соёлтой хурдан шуурхай үйлчлэхэд оршино.

Бидний уриа

Эелдэг харилцаа

Соёлтой үйлчилгээ иргэн бүрт

Компанийн захирлаар Б.Дорж, И.Бодь, З.Доржсүрэн, Я.Лхагвасүрэн, Г.Бямбасүрэн, П.Дэлгэрнаран, Р.Мөнхбат, М.Цэвээн-Очир нар ажиллаж байсан.

1997 онд захиргааны 58 ажилтан, 174 жолооч, 143 мөнгө хураагч нийт 371 ажилтантайгаар 6 чиглэлд 143 автобусаар нийслэлийн иргэдэд үйлчилж байсан. Төлөвлөгөөт зорилтыг ханган биелүүлэх, үйлчилгээний хэвийн үйл ажиллагааг хангах талаар: 554.88 мянган хүн тээж, 45.9 мянган цаг төлбөртэй үйлчилж, 700.547.6 мянган төгрөгийн орлого оруулж, 249.696 мянган хүн, километрийн ажил гүйцэтгэсэн байна.

1998 онд тус компанийн захирлаар Г.Лхагва-Очир, дэд захирлаар Я.Лхагвасүрэн нар ажиллаж. 155 жолооч, 118 мөнгө хураагч, 57 ажилтан албан хаагчтай нийт 333 ажилтантай. 99 автобус, үйлчилгээний машин 14 нийт 109 хөдлөх бүрэлдэхүүнтэй. 7051.5 мянган хүн тээж, 15.5 мянган төлбөртэй цаг үйлчилж 703809.2 мянган төгрөгийн орлоготой, 937406.5 мянган төгрөгийн зардалтай, 29523.4 мянган хүн километрийн ажил гүйцэтгэж, орлогын даалгаврыг 96.9 хувиар, цагийнтүвшинг 71.0 хувиар тус тус биелүүлсэн. Тухайн онд хамт олны дундаас “Хөдөлмөрийн гавьяаны улаан туг”-ийн одон 2 хүн, “Онц тээвэрчин” 16, “Осолгүй манлай” 5 хүн төрөн гарсан.

1999 онд 97 жолооч, 80 мөнгөхураагч, 45 ажилтан албан хаагчтай нийт 222 ажилтантай, 104 автобус хөдлөх бүрэлдэхүүнтэй төлөвлөгөөт зорилтыг ханган биелүүлэх, үйлчилгээний жигд ажиллагааг хангах талаар 4215.8 мянган хүн тээж,

6607 төлбөртэй цаг үйлчилж, 457286.2 мянган төгрөгийн орлоготой, 17706.3 мянган хүн километрийн ажил гүйцэтгэж, орлогын даалгаврыг 84.4 хувиар, цагийн түвшинг 84.4 хувиар тус тус биелүүлсэн.

2001 онд шугамд нийт 87 автобус, 163 жолооч, 153 мөнгөхураагч, нийт 361 ажилтан, ажиллагсадтай. 5397.3 мянган зорчигч тээвэрлэж, 22668.7 мянган хүн км ажил гүйцэтгэсэн. Нийт 879112.3 мянгант өгрөгийн орлого, шугам цагийн гүйцэтгэл 84.5 хувиар, орлогыг 100.5 хувиар биелүүлж ирсэн байна. БНСУ-аас 57 автобусыг оруулж ирж парк, шинэчлэл хийж байжээ.

2002 оноос компанийн удирдлагын бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэн Ашиглалт, бизнес төлөвлөлтийн, Техникийн, Санхүүгийн гэсэн 3 албатайгаар ажиллаж байсан. Тухайн үед 430 гаруй ажилтан, ажиллагсадтай, нийтийн тээврийн үйлчилгээний том оврын 72 автобус, бусад үйлчилгээний 7 автобустай, засвар техникийн үйлчилгээний байр, талбай граш контор, диспетчерийн байр, хөдлөх бүрэлдэхүүн оролцуулаад нийт 1876.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгөтэй. Зорчигч тээвэрт 171.8 мянган цаг ажиллаж, 6860.8 мянган зорчигч тээвэрлэж, 22132.7 мянган хүн километрийн ажил гүйцэтгэж, 1140.9 сая төгрөгийн орлоготой ажилласан. Мөн ашиглалтын зардал өндөртэй норм дууссан Лиаз 677 маркийн автобуснуудыг данснаас хасч БНСУ-д үйлдвэрлэгдэн ашиглагдаж байсан 54 автобусыг нэмж авснаар тус компанийн хөдлөх бүрэлдэхүүн нь БНСУ-д үйлдвэрлэгдсэн АЕРО сити 520, 540 маркийн 72 автобустай болсноор паркийн хүчин чадал нэмэгдэн ажил үйлчилгээний орлого 2,5-3 дахин нэмэгдсэн байна.

2003 онд 4912.9 мянган хүн зорчигч тээвэрлэж, 16703.9 мянган хүн км төлбөрт цаг үйлчилж, 777840.2 мянган төгрөгийн орлоготой, шугам цагийн төлөвлөгөөг 74 хувиар биелүүлсэн. 2003 оны 09 дүгээр сард менежментийн хувьчлал явагдсанаас 50 шахам автобус ямарч шийдвэргүйгээр задлагдан, нийт 72 автобуснаас шугаманд 30 автобусаар үйлчилж, 42 автобус ашиглагдах боломжгүй байсан. 90 жолооч, 96 мөнгөхураагч, 69 ажилтан албан хаагч, нийт 255 ажилтантай байсан. Нийт 385 ажилтан, ажиллагсадтай, 2219343280 мянган төгрөгийн үндсэн хөрөнгөтэй. 3332.7 мянган хүн зорчигч тээж, 525109.4 мянган төгрөгийн орлоготой, 11334.5 мянган хүн, км ажил гүйцэтгэж, орлогын даалгаврыг 93 хувиар, 63711 цаг шугамд ажиллаж, шугам цагийн даалгаврыг 62.2 хувиар биелүүлж байсан байна. 80 хөдлөх бүрэлдэхүүнтэй, БНСУ-д үйлдвэрлэгдсэн 72 автобустай, 54 автобус ашиглагдахгүй, 20 автобусаар шугамд үйлчилгээ явуулж байсан. Энэ онд өмч хувьчлал буруу явагдснаас болж байгууллагад их хэмжээний өр төлбөр үүсч, эдийн засгийн чадавхи буурсан. Ажилчдын цалингийн өглөг 34315462.56 мянган төгрөг, татварын өглөг 26605779.09 мянган төгрөг, нийгмийн даатгалын өр 74391399.50 мянган төгрөг, банкны богино хугацаат зээл 337000000 мянган төгрөг, урт хугацаат зээл 1684546333.87 мянган төгрөг болон бусад өглөг 12851934.82 мянган төгрөгийн нийт 2851789738 мянган төгрөгийн өр төлбөртэй байлаа. Мөн ажилчдын нийгмийн даатгалд 2005 онд 105981.6 төгрөг, 2006 онд 121128.0 төгрөг, 2007 онд 145980,3 төгрөгийн өртэй.

2005-2007 онд засвар, техникийн үйлчилгээний байр, хөдлөх бүрэлдэхүүн оролцуулаад нийт 1210.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгөтэй, 92 ажилтан,

ажиллагсад нийтийн тээврийн үйлчилгээний 15 автобус, бусад үйлчилгээний 3 автобус, автомашинтайгаар ажиллаж байсан.

2008 онд 30 гаруй ажилтан, ажиллагсадтай, 6 автобустай үйл ажиллалгаа явуулж байсан.

2009 оны эхэнд 6 автобус, 30 гаруй ажиллагсадтай нийтийн тээврийн нэг чиглэлд ажиллаж байсан бол Нийслэлийн нийтийн тээврийн сайжруулах зорилгоор 2009 оны 4 дүгээр сараас эхлэн Засгийн газрын хөрөнгө оруулалтаар БНСУ-д үйлдвэрлэсэн DAEWOO BUS BS-106 маркийн 80 автобусаар парк шинэчлэл хийгдэж, засвар техникийн үйлчилгээний байр талбай, граж, диспетчерийн байр, контор, хөдлөх бүрэлдэхүүн оролцуулаад 8620.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгөтэй үйл ажиллагаа явуулж байна. Компани маань энэ үеэс эхлэн Ашиглалтын, Техникийн, Санхүүгийн, Захиргаа, хүний нөөцийн гэсэн 4 албатай, 370 гаруй ажиллагсад, нийтийн тээврийн үйлчилгээний их багтаамжийн 80 автобус, бусад үйлчилгээний 3 автомашинтайгаар ажиллаж үйлчилгээгээ явуулж байна. Байгууллагын бүтэц зохион байгуулалт өөрчлөгдөх үед орон тоо нэмэгдэхэд захиргааны ажилтнуудын ажиллах нөхцөл бололцоо нэлээн хүндрэлтэй байсан. Суух өрөө тасалгаа, компьютер техник хэрэгсэл, суух сандал ширээнээс эхлээд авах зүйл нэлээн байсан бөгөөд тэдгээрийг худалдан авах өмнөх хуримтлагдсан өрийг дарах зэрэг бэрхшээлтэй асуудлууд цөөнгүй байлаа. Гэвч эдийн засаг, санхүүгийн түвшинг дээшлэж, байгууллагын хуримтлагдсан өрнөөс 649323,3 мянган төгрөгийг төлж барагдуулсан. Ажилчдын цалин хөлсийг цаг хугацаанд нь өгч, түрээслэгч байгууллагуудаас ажлын байруудыг буцаан, сэргээн засварлах ажлуудыг хийж эхэлсэн.

2010 онд 4 албатай нийт 371 ажилтан, 80 автобустай. 7 чиглэлд 73 гаралтаар нийтийн тээврийн үйлчилгээг эрхлэн явуулж байсан. Өглөөний графикийг 21764 машин өдөр, шугамд 277,2 мянган цаг ажиллаж, 169.1 мянган рейс буюу 23224.6 мянган зорчигч тээвэрлэн, 78963,8 мянган хүн, километрийн ажил гүйцэтгэн ажилчдын ажиллах жигд үйл ажиллагаа хангагдаж, ур чадвар дээшилсэн. Шугамын үйлчилгээнээс 3220.9 мянган төгрөгийн орлого, оюутны хөнгөлөлтийн нөхөн олговроос 13334.8 мянга, өндөр настан, тахир дутуу иргэдийн 1131.1 мянга, цэрэг цагдаагийн үйлчилгээнээс 5,3 мянган төгрөг, нийт 5742.1 мянган төгрөгийн орлогыг татан төвлөрүүлсэн. Орлогын биелэлт 99.3 хувь, үүнээс шугамын орлого 92.3 хувь биелсэн.

Нийслэлийн нийтийн тээврийн газартай байгуулсан “Техникийн бэлэн байдлын коэффициент”-ын дагуу 1.0 парк ашиглалтын коэффициент 91.2 хувьтай, техникийн бэлэн байдал хангагдсанаар байгууллагын цагийн түвшинг 95-98 хувиар биелүүлж ажилласан. Техникийн засвар үйлчилгээний графикийг ажлын 56 хоногт, Техникийн үйлчилгээг 1,2-г хийхээр төлөвлөж, мөрдөж ажилласан нь шугам замд аваар осолгүй ажиллах, техникийн эдэлгээг уртасгахад ач холбогдолтой болсон юм. Нийтийн тээврийн үйлчилгээнд анх удаа мэдээллийн технологийн үйл ажиллагааг нэвтрүүлж 50 автобусанд дэлгэц суурилуулж, мэдээ мэдээлэл, зар суртчилгаа, санамж, зөвлөгөөг зорчигчдод хүргэж ажилласан. Мөн 20 автобусанд утасгүй интернет суурилуулан ажиллуулах ажлыг санаачлан “Телемакс” компанитай хамтран иргэд, зорчигчдод үнэ төлбөргүй интернет ашиглах боломжийг бүрдүүлсэн.

Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын ажлын үр дүнд хийгдсэн зүйлсээс дурьдвал:

- Конторын дээврийн засварыг хийж гүйцэтгэхэд 27.180.2 мянган төгрөг,
- Конторын барилга байгууламж, мотор цехийн дотор талын цахилгааны мантож, гадна гражийн дээд талын гэрэлтүүлгийн ажлыг хийж гүйцэтгэхэд 25.910.7 мянган төгрөг,
- Засварын байрны урсгал засварт 9.695.5 мянган төгрөг,
- Засварын байрны дотор талын дотор талд 13.762.0 мянган төгрөгийн хөрөнгийг тус тус зарцуулсан.

2010 оны төлөвлөгөөнд тусгагдаагүй “Ногоон төгөл хувьсгал” үндэсний хөтөлбөрийн хүрээнд компанийн өмнөх 240м² талбайг зүлэгжүүлэх, 51 м² талбайг өнгөт хавтангаар явган хүний зам, 220 ширхэг мод үрслүүлж, цэцгийн мандал хийсэн. Мөн 55.14м хашааг шинэчлэн 1.630.000 төгрөгийн хөрөнгө зарцуулсан.

Байгууллагын цахим хаягтай болж “Амьдрал” сайтын байгууллагадтай хамтран ажиллаж, байгууллагынхаа үйл ажиллагааг олон нийтэд сурталчилахад их чухал алхам болсон. “Автобус-3” цахим хаяганд иргэдээс ирсэн саналаар байгууллагын үйл ажиллагааг 80 хувь нь сайн гэсэн үнэлгээг өгсөн. Энэ онд М:50, 51, 52 гэсэн 3 чиглэлд шинэ шугам нээснээр иргэдэд нийтийн тээврээр зорчих таатай нөхцөл бүрдүүлж, шугамын үйл ажиллагаа жигдэрсэн.

Парк шинэчлэлт хийхээс өмнө сард 10.3 сая төгрөгийн нөхөн олговор, шугамын орлого 300.0-400.0 мянган төгрөг ордог байсан учир төсвийг үр өгөөжтэй зарцуулах боломжгүй, харилцагч байгууллагууддаа ихээхэн хэмжээний өр авлага үүссэн байсан.

Парк шинэчлэлт хийснээр шугамын гаралт, орлого нэмэгдсэн. Жолоочийн хариуцлагын даатгал, тээврийн хэрэгслийн даатгалд бүрэн хамрагдсанаар нөхөн төлбөрт хамрагдах боломжийг бүрдүүлж чадсан.

Хамт олны дундаас ажил үйлсээрээ хамт олноо хошуучлан ажилласан тэргүүний ажилтан ажиллагсад олноор төрөн гарсан. Захирал П.Дэлгэрнаран, Ашиглалтын албаны дарга Х.Пүрэв “Хөдөлмөрийн гавьяаны улаан туг”-ийн одонгоор, Захиргаа хүний нөөцийн албаны дарга Я.Рэнцэнханд, сэлбэгийн нярав У.Тунгалаг нар “Хөдөлмөрийн хүндэт” медалиар, жолооч Н.Мөнхбаяр Нийслэлийн нийтийн тээврийн салбарын “Аварга жолооч”-оор, “Осолгүй манлай” 5, “Онц тээвэрчин” 16 хүн тус тус шагнагдаж, байгууллагаараа Нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээний салбарын “Тэргүүний байгууллага”-аар шалгарсан явдал нь манай хамт олны ажлын амжилтын нэг том илрэл юм.

2011 онд байгууллагын үүсч хөгжсөний 20 жилийн ой тэмдэглэн өнгөрүүлсэн. Манай хамт олон урьд оны амжилтаа бататгаж илүү ихийг бүтээх эрмэлзэл дүүрэн ажилласан. 20 жилийн ойтой холбогдуулан багагүй ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

Эхний 10 сарын байдлаар өдөрт дунджаар 72 автобус шугамд гарч, өглөөний графикийг 19500.0 машин өдөр, шугамд 257207 мянган цаг ажиллаж, 74446 рейс, 233665 мянган зорчигч тээвэрлэн 46423 мянган хүн км ажил гүйцэтгээд байна. Зорчигч тээврийн орлогын төлөвлөгөөгөөр 36041073 төгрөг төвлөрүүлж, орлогыг 102 хувиар биелүүлж, техникийн бэлэн байдлын коэффициент 1,0 парк

ашиглалтын коэффициент 92 хувьд хүргэж, Нийслэлийн Нийтийн тээврийн газартай байгуулсан “Ажил үйлчилгээний гэрээ”-г 95-98 хувиар биелүүлж ажилласан байна. Энэ жилийг “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан инженер, техникийн ажилтан 4, захиргааны ажилтан 4, жолооч 33, мөнгө хураагч 24, бага тушаалын ажилтан 3 нийт 69 хүнийг ажлын байраар шинээр хангаад байна. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг зохион байгуулах журмын дагуу анхан шатны зааварчилгааг 95 ажилтанд 190 цагийн сургалт, зааварчилгаа, Захиргаа аж ахуй, инженер техникийн ажилтнууд, жолооч, мөнгө хураагч нийт 320 хүнд давтан зааварчилгааг өгсөн.

Ажилчдын эрүүл мэндийн тал дээр байнгын судалгаатай болж, шаардлагатай хүмүүсийг байгууллагын эмчийн байнгын хяналтад авсан. Эрүүл мэндийн үзлэгийг жилд 2 удаа зохион байгуулж ажилтан, ажиллагсдаа хамруулаад байна. Бүх автобусад анхан шатны тусламж үзүүлэх эмийн санг байрлуулсан.

“Хүний хөгжлийн жил” болгон зарласантай холбогдуулан дотоод аялалуудыг зохион байгуулж ажиллаа. Хамрын хийдэд 33 хүн, Архангай аймагт 15 хүн, Хөвсгөл аймгийн чиглэлд 20 хүнийг тус тус аяллуулсан.

20 жилийн ойн ажлын хүрээнд байгууллагын ахмад тээвэрчдийг хүлээн авч хүндэтгэл үзүүлсэн. Энэ арга хэмжээний үеэр ахмад тээвэрчин С.Төмөрбат, Б.Далай, Д.Сумъяа нарыг “Онц тээвэрчин” цол тэмдэг, “Яамны жуух бичиг”-ээр тус тус шагнасан. Байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журам”-д заасны дагуу гавьяаныхаа амралтанд суусан 2 өндөр насад 14273020 төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламжийг олгосон.

Байгууллагын нийт ажиллагсдын дунд “Байгууллагын шилжин явах цом”-ын төлөөх спортын таван төрлийн тэмцээнийг амжилттай зохион байгуулсан. Мөн нийтийн тээврийн үйлчилгээ эрхэлдэг байгууллагуудын жолооч нарын дунд “Автобус-3” компанийн нэрэмжит “Уран жолоодлого”-ын тэмцээнийг зохион байгуулсан. Уг тэмцээнд 14 байгууллагын 20 жолооч оролцож “Автобус-3” компанийн жолооч Б.Нямпүрэв тэргүүн байр, 2 дугаар байранд “Автобус нэгдэл” компанийн жолооч н.Жанчив, 3 дугаар байранд “Автобус-3” компанийн жолооч Б.Ууганбаяр, 4 дүгээр байр буюу тусгай байранд “Автобус-3” компанийн жолооч Д.Батгэрэл нар шалгарсан.

Ажлын байранд дахь сахилга батыг дээшлүүлэх, шугам замд аваар осолгүй ажиллах талаар жолооч, мөнгө хураагч нартай 20 удаагийн сургалт семинарыг Замын цагдаагийн газар, Сүхбаатар дүүргийн Замын цагдаагийн хэлтэс, Нийслэлийн Нийтийн тээврийн газрын байцаагч нартай хамтран зохион байгуулсан нь үр дүнгээ өгсөн. 1,3,6 дугаар сард ямар нэгэн зөрчилгүй, 2 сард 12 зөрчил, 4 сард 15 зөрчил, 5 сард 7 зөрчил гаргасан байна. Зөрчил гаргасан жолооч, мөнгө хураагч нарт арга хэмжээг тухай бүрд нь тооцож, зөрчлийг арилгаж ажилласан.

Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэс, Автотээврийн газрын хамтран зохион байгуулсан тендерт оролцож, “Нийтийн зорчигч тээврийн мэргэшсэн болон D ангиллын жолооч бэлтгэх сургалт” явуулах эрх авч, сургалтын танхимаа нээн ажиллуулж 13 удаагийн төгсөлтөөр нийт 250 мэргэшсэн жолооч бэлтгэн 100 хувь амжилттай төгсгөн ажлын байраар 100 хувь хангасан.

Ажилтан ажиллагсадтай Хөдөлмөрийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийг үндэслэн “Хөдөлмөрийн гэрээ” байгуулж, Ажлын байрны тодорхойлолтоор ажил үүргийн биелэлтийг гарган ажиллаж хэвшсэн. Монголын хүний нөөцийн институттэй хамтран “Хүний нөөцийн үндсэн үзүүлэлтүүдийг тэнцвэржүүлэх, албадыг чадваржуулах шинэтгэлийн хөтөлбөр”-ийг зохион байгуулсны үр дүнд ажилчдын ажилдаа хандах хандлага өөрчлөгдөж, ажилчдын ажлын идэвх сайжирсан. Ажилчдын нийгмийн даатгалын дэвтрийг 100 хувь баталгаажуулж, нийгмийн даатгалын хуримтлагдсан өр болох 257958.0 төгрөгийг төлж барагдуулсан. Нэг ажилтны дундаж цалин 157.6 төгрөг буюу 34.5 хувиар нэмэгдсэн.

Бүтээн байгуулалт хөрөнгө оруулалтын талаар:

- Ажилчдын хувцас угааж, хатаах бүрэн автомат угаалгын машин 3.307.100 төгрөг,
- Сургалтын төвд эд хогшил, компьютер зэрэг нийт 20.040.000 төгрөг,
- Конторын шатыг засварлахад 10.000.000 төгрөг,
- Явган хүний 50 м² зам тавихад 2.150.000 төгрөг,
- 1 давхарын ариун цэврийн өрөөг тохижуулахад 1.930.500 төгрөг,
- 2 давхарын коридорыг тохижуулахад 68663000 төгрөг,
- Захирлын өрөөг тохижуулахад 1843400 төгрөгний бүтээн босголт хөрөнгө оруулалтын ажлыг хийж, компанийн ажилчдын ая тухтай ажиллах орчныг бүрдүүлээд байна.

2012 оны 03 дугаар сараас “Автобус-3” компанийн захирлаар Р.Мөнхбат томилогдон ажиллаж байна. Манай байгууллага нь нийтийн тээврийн салбарт үйл ажиллагаагаа амжилттай явуулж, өнгөрсөн 20 жилд салбартаа чухал байр суурийг эзлэх болсон. Нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээний 8 чиглэлд 72 гаралтаар иргэдэд үйлчилж байна. Нийслэлийн нийтийн тээврийн газартай байгуулсан гэрээний биелэлтийг 100 хувь буюу бүрэн хангалттай үнэлгээгээр дүгнүүлж 26 автобус баазуудаас тэргүүн байрыг эзэлсэн. Энэ онд 4 албатай 410 гаруй ажилтан ажиллагсадтайгаар үйл ажиллагаагаа явуулж байна. Зорчигч тээвэрлэлтийг 91%, шугам цагийн гүйцэтгэлийг 82% парк ашиглалт техникийн бэлэн байдлыг 90%-д тус тус хүргэхээр зорилт тавин бүрэн хэрэгжүүлж ажиллаж байна. Бид чанартай үйлчилгээг хэрэглэгчдийн сэтгэл ханамжид нийцүүлэн хүргэж, орчин үеийн дэвшилтэт техник технологийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн, эх орныхаа хөгжил дэвшилд тодорхой хувь нэмэр байнга оруулсаар байх болно.

Нийтийн тээврийн үйлчилгээнд жолоочийн оролцоогүйгээр буудал зарлах систем Монголд анх удаа нэвтрүүлэн оруулж ирж үйлчилгээнд үр ашигтайгаар ашиглаж байна.

2013 онд байгууллагын Захирлаар М.Цэвээн-Очир, Захиргаа, удирдлагын хэлтсийн даргаар С.Бүтэмж, Санхүү, бүртгэлийн хэлтсийн даргаар Б.Энхтуяа, Тэвээрлэлт, үйлчилгээний хэлтсийн даргаар А.Ганболд, Техник, технологийн хэлтсийн даргаар С.Эрдэнэтовч нар ажиллаж байна. Захиргаа, удирдлагын хэлтэс, Санхүү, бүртгэлийн хэлтэс, Тэвээрлэлт, үйлчилгээний хэлтэс, Техник, технологийн хэлтэс гэсэн 4 хэлтэстэй. Тэвээрлэлт, үйлчилгээний хэлтэс 3 хэсгийн

зохион байгуулалтайгаар Захиргаа, инженер техникийн ажилтан-85, 170 автобусны жолооч, 170 мөнгө хураагчтай, өдөрт 72 гаралтаар 8 чиглэлд нийтийн тээврийн үйлчилгээг эрхлэн явуулж байна.

Тайлангийн хугацаанд 4,2 сая хүүхэд 16,1 сая том хүний нийт 20,3 сая зорчигч тээвэрлэж, тээвэрлэлтийн ажлын гүйцэтгэлийг 107,3 хувиар биелүүлж, сардаа 432.9 сая төгрөгийн орлогыг шугамын үйл ажиллагаанаас олохоор төлөвлөснөөс 446.6 сая төгрөгийг олж орлогын төлөвлөгөөг байгууллагын хэмжээнд 103,1 хувиар биелүүлэн ажилласан. Шугам зам ажиллах цаг графикийн мөрдөлт: Нийт 170 жолооч, 170 мөнгө хураагч нарыг 2 ээлжийн зохион байгуулалтайгаар хөдөлмөр зохион байгуулалтыг хийж Нийслэлийн тээврийн газартай байгуулсан гэрээний дагуу 159944.5 цаг рейс гүйцэтгэж, шугам цагийн төлөвлөгөөг 309722 цаг буюу 97,2 хувиар биелүүлж ажилласан. Нийслэлийн тээврийн газартай байгуулсан гэрээг хугацаанд нь сар тутам хангалттай, хангалттай сайн гэсэн үнэлгээтэй дүгнүүлж, цагийн түвшинг 95,3-98,8 хувь, рейсийн түвшинг 86,7-91,5 хувьд хүргэж ажилласан.

Нийтийн тээврийн үйлчилгээнд ажиллаж байгаа тээврийн хэрэгслүүдийн техникийн бүрэн бүтэн байдлыг хангаж ажиллах зорилгоор 15000-16000 км /63 хоног/ тутамд Техникийн 2-р үйлчилгээг төлөвлөн сард дунджаар 36-41 автобус буюу нийт тайлангын хугацаанд давхардсан тоогоор 399 автобус хамрагдсан байна. Харин хөдлөх бүрэлдэхүүний 4000-4300 км /21 хоног/ тутамд Техникийн 1-р үйлчилгээг төлөвлөн сард дунджаар 74-76 автобус буюу тайлангын хугацаанд давхардсан тоогоор 775 автобус хамрагдсан байна. Өнгөрөгч жилүүдийн мөн үетэй харьцуулахад Техникийн 2-р үйлчилгээ батлагдсан графикын дагуу 100%, Техникийн 1-р үйлчилгээ нь 85 % -тай хийгдсэн. Үүний үр дүнд техникийн саатал бага гарч парк ашиглалтыг 90-95 хувьд хүргэж ажиллаа. Цаашид урсгал их засварын ажлыг төлөвлөн гүйцэтгэх шаардлагатай байна.

Байгууллагын дотоод удирдлагын програм нэвтрүүлсэн байдал: Албан байгууллагын нэрийн хуудас, нэр хүнд, ашиглахад хялбар ойлгомжтой, байгууллагын ажилчдын хоорондын мэдээлэл дамжуулалт хурдан шуурхай, мэдээллийг урт хугацаанд хадгалах, цаасны хэрэглээг багасгах, байгууллагын нийтлэг хэрэглээ, соёлтой харилцааг бий болгох үүднээс “Microsoft Outlook” программыг нэвтрүүлэн ажиллаж байна. Үүний үр дүнд байгууллагын нууцлал алдагдахгүй, байгууллагын дотор зохион байгуулагдаж буй аливаа үйл ажиллагаа нь цаг алдалгүй нийт ажилтан ажиллагсдад зэрэг хүрэх боломжийг бүрдүүлсэн.

Байгууллагын туг далбаа мандуулах ёслолын арга хэмжээ: 2009-2013 оны 05 дугаар сарын 16-ны өдөр хүртэл байгууллагын далбаа цагаан өнгөтэй байсан. Байгууллагын туг далбааг шинэчлэхийн тулд 2013 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн А/19 дүгээр тушаалаар байгууллагын туг, далбааны загварын урадаан зарлаж дүгнэхэд Н.Баярбат даргатай 3 хэсгийн хамт олны хийсэн бүтээл шалгарч өргөмжлөл мөнгөн шагналаар шагнуулсан. 2013 оноос байгууллагын туг, далбаа шар дэвсгэртэй, байгууллагын лого, нэрийг бичиж

өөрчилсөн. Цэцээ –гүний оройд туг мандуулах ёслолын үйл ажиллагааг 2013 оны 05 дугаар сарын 17-ны өдөр зохион байгуулсан.

Бэсрэг наадам: Авто тээврийн салбар үүсч байгуулагдсаны 88 жилийн ойг тохиолдуулан байгууллагын анхны “Бэсрэг наадам”-ыг 2013 оны 07 дугаар сарын 26-ны өдөр зохион байгуулж, байгууллагын аварга бөхөөр М.Пүрэвхүү түрүүлж, мөнгөн шагнал, 32 инчийн зурагт, Л.Буян-Орших үзүүрлэж мөнгөн шагнал, угаалгын машины эзэн болсон.

Нийслэлийн удирдлагаас цаг үеийн асуудлаар өгсөн үүрэг даалгаврын биелэлт: Нийслэлийн Засаг даргын 2013 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн “Захирамжлалын баримтад цахим хувь үйлдэх тухай” А/452 дугаар захирамжийн дагуу байгууллагын Захирлын 1964-2013 оны боловсон хүчний болон үйл ажиллагааны чиглэлээр гаргасан тушаал, хурлын тэмдэглэлүүдийг сэлбэн засварлаж, цахим хэлбэрт оруулах ажлыг 100 хувь хийж дуусгасан.

Бидний бахархал: Энэ онд манай байгууллагаас ажил үйлсээрээ хамт олноо хошуучлан ажиллаж Төрийн дээд одон медаль “Алтан гадас одон”-оор аж ахуйн дарга Ч.Гантөмөр, засварын инженер Ш.Батсүх, “Хөдөлмөрийн хүндэт медаль”-аар шалгах механик М.Эрдэнэдалай, Ж.Содномпил, засварчин Л.Цэцэгмаа, Зам тээврийн яамны шагнал “Онц тээвэрчин” цолоор 15 ажилтан, Яамны “Жуух бичиг”-ээр 23 ажилтан, Нийслэл Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн шагнал 6 ажилтан, Сүхбаатар дүүргийн шагнал 5 ажилтан, Монголын Залуучуудын Холбооны шагнал 10 ажилтан тус тус шагнагдсан. Нийслэлийн нийтийн тээврийн байгууллагуудын дунд зохион байгуулагдсан системийн аварга шалгаруулах спортын тэмцээнд гар бөмбөгийн тэмцээнд эмэгтэй баг тамирчид 3 байр эзэлж, “Хүрэл медаль”-ийн эзэд болсон. “Уран жолоодлого”-ын тэмцээнд Тээвэрлэлт, үйлчилгээний хэлтсийн 3 хэсгийн жолооч Х.Цогбадрах 2 дугаар байр эзэлж, мөнгөн медалийн эзэн болсон

Захиргаа, удирдлагын хэлтэс: Тус хэлтсийн даргаар Л.Нямжаргал, П.Цэрэндаш, М.Өлзийхүү, Л.Туяа, Д.Ундармаа, Я.Рэнцэнханд, Б.Нямжав нар ажиллаж байсан. 2013 оноос тус хэлтсийн даргаар С.Бүтэмж томилогдон ажиллаж байна. Захиргаа, удирдлагын хэлтсийн бүрэлдэхүүн дотоод хяналт шалгалтын ажилтан Б.Бадамцэцэг, дотоод ажил төлөвлөлт, хэрэгжилт хариуцсан ажилтан Л.Тулга, хуулийн зөвлөх Б.Солонго, олон нийттэй харилцах ажилтан Ч.Хишигсүрэн, эдийн засагч Б.Ариумаа, сургалтын төвийн менежер Б.Төөрүүл, хүний нөөцийн менежер П.Онон, IT инженер Ж.Батбаяр, эмч Д.Мэдэхгүй, захирлын туслах Б.Уранцэцэг, аж ахуйн жолооч Ч.Дамирансүрэн, Л.Төгөлдөрсайхан, үйлчлэгч Б.Ууганжаргал, Б.Өнөртуяа, С.Бямбадолгор нар ажиллаж байна. Дүрэм, журам, гэрээний талаар: Байгууллагын дүрэмийг шинэчлэн Нийслэлийн Засаг даргаар батлуулан мөрдөн ажиллаж байна. Байгууллагын дүрэм өөрчлөгдсөн холбогдуулан бүтэц орон тоо, ажлын байрны гүйцэтгэх ажил өөрчлөгдсөнтэй ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн баталгаажуулж, мөрдөн ажиллаж байна.

Хүний нөөцийн бодлогын талаар: Нийслэлийн Засаг даргын батлуулсан бүтэц орон тооны хүрээнд энэ онд шинээр дотоод ажил төлөвлөлт, хэрэгжилт

хариуцсан ажилтан-1, хэвлэл мэдээлэл олон нийттэй харилцах ажилтан-1, эдийн засаг, санхүү төлөвлөлт, хэрэгжилт хариуцсан ажилтан -1, ерөнхий механикийн инженер-1, конторын цахилгаанчин-1, мужаан-1, тэрэг угаагч-1, халуун усны үйлчлэгч -1 гэх мэт 10 ажлын байрыг шинээр бий болгон ажиллуулсан.

Сургалт, сурталчилгааны ажлын талаар: Ажилчдын мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх үүднээс МИС-ийн магистрантурын сургалтанд ахлах инженер Ц.Мөнхбаатар, удирдлагын хөгжлийн акидемд бичиг хэргийн ажилтан Л.Тулга хүний нөөцийн бодлого, төлөвлөлт, хөдөлмөр зохион байгуулалтын чиглэлээр тус тус сургасан. Нийт жолооч мөнгө хураагч нарт Замын цагдаагийн газартай хамтран сургалт 2 удаа зохион байгуулсан. Байгууллагын дэргэдэх “Нарны зам” сургалтын төв нийт 70 жолоочийг нийтийн тээврийн мэргэшсэн жолоочийн сургалтанд хамруулж 100 хувь амжилттай төгсгөж, ажлын байраар 100 хувь хангасан. Тус хэлтэс нь ажилтан албан хаагчийн сурах ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр боловсруулах, мониторинг, дотоод хяналт шалгалт, байгууллагын үйл ажиллагааны стратеги хэтийн төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлнэ. Албан хэрэг хөтлөлтийг хууль тогтоомжийн дагуу хөтлөн явуулж, архивын болон нууц баримт бичгийг хариуцна. Байгууллагын цахим мэдээллийн хуудас, сан компьютерийн програм хангамжын хэвийн нөхцлийг бүрдүүлж, програм хангамжаар хангана. Хүний нөөцийн асуудлыг судалж, шийдвэрийн төсөл боловсруулна. Байгууллагад хандан ирсэн өргөдөл гомдол хүсэлтийг хүлээн авч хуулийн дагуу шийдвэрлэн, аливаа эрх зүйн дэмжлэг үзүүлнэ.

Тээвэрлэлт, үйлчилгээний хэлтсийн даргаар н.Энхбаасан, Я.Лхагвасүрэн, Ж.Пүрэвсамбуу, Б.Нямсүрэн, Х.Пүрэв, Б.Төөрүүл нар ажиллаж байсан. 2013 оноос А.Ганболд тус хэлтсийн даргаар ажиллаж байна. Тус алба нь удирдлагын 9 хүний бүрэлдэхүүнтэй, 3 хэсгийн зохион байгуулалттайгаар байгууллагын үндсэн үйлдвэрлэлийн үйл ажиллагааг ханган явуулж ажилладаг. Хэсгийн дарга Х.Алтансүх, Ц.Дашцоодол, Н.Баярбат, ээлжийн инженер Б.Цэцгээ, О.Энхтунгалаг, М.Энхтулга, Н.Алтантуяа, ахлах менежер Ч.Гантөмөр, тэрэг угаагч Т.Болдбаатар, Т.Эрдэнэбат, Нармандах, үйлчлэгч Отгонцэцэг нар ажиллаж байна. Тээвэрлэлт, үйлчилгээний хэлтсийн нэгдүгээр хэсэг нь 27 автобустай, 56 жолооч, 56 мөнгө хураагчтай, хоёрдугаар хэсэг нь 25 автобус, 50 мөнгө хураагч, 50 жолооч, гурав дугаар хэсэг нь 26 автобустай 52 жолооч, 52 мөнгө хураагчтайгаар ажилдаг. Нийслэлийн тээврийн газраас баталсан цаг график, маршрутын дагуу, шугамын үйлчилгээ шуурхай зохион байгуулж, жолооч, мөнгө хураагч нарын ажил амралт хөдөлмөр зохион байгуулалтын хувиарийг оновчтой хийх, байгууллагын төлөвлөгөөт даалгавар цаг рейс болон орлогын төлөвлөгөө, үйлдвэрлэлийн ажиллагааг жигд ханган биелүүлэн ажиллаж байна. Тайлангийн хугацаанд 4,2 сая хүүхэд 16,1 сая том хүний нийт 20,3 сая зорчигч тээвэрлэж, тээвэрлэлтийн ажлын гүйцэтгэлийг 107,3 хувиар биелүүлж ажилласан.

Техник, технологийн хэлтсийн даргаар н.Ядамсүрэн, Ш.Ганбаатар, н.Эрдэнэбилэг, З.Доржсүрэн, Ш.Батсүх, Х.Пүрэв, Р.Раднаабазар нар ажиллаж байсан. 2012 оноос С.Эрдэнэтовч нар өнөөг хүртэл даргаар ажиллаж байна.

Засварын хэсэг, шалгах хэсэг, механикийн хэсгийн зохион байгуулалттайгаар байгууллагын хөдлөх бүрэлдэхүүний техникийн бүрэн бүтэн байдалыг ханган ажилладаг. Ахлах инженер Ц.Мөнхбаатар, засварын инженер М.Пүрэвдорж, шалгах механик Ж.Содномпил, Ш.Ууганбаатар, засварын механик, тэрэг тавигч Я.Дашдорж, Эрдэнэбилэг, С.Сүхбаяр, нийт 15 засварчинтайгаар техникийн аюулгүй байдлыг хангаж, засвар үйлчилгээг цаг хугацаанд нь чанарын өндөр түвшинд хийж техникийн хувьд шугам замд явах автобусны бүрэн бүтэн байдалыг ханган ажиллаж байна. Засварын цехийн тоног төхөөрөмж шинэчлэн Токарын суурь машин засварын тоноглолтой тусгай зориулалтын чирэгч машин худалдан авч үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд ашиглан засварчдын ажлыг хөнгөвчилж байна. Автобусанд техникийн үйлчилгээ нэгийг 45 хоногт нэг удаа, техникийн үйлчилгээ хоёрыг 60 хоногт нэг удаа хийснээр үйлчилгээнд гарч буй автобуснууд техникийн сааталаар зогсох нь багасч парк ашиглалтын коэффициентийг 0.1% аар буюу 92.4% аар ашиглаж байна.

Санхүү, бүртгэлийн хэлтсийн даргаар Б.Отгонхүү, Я.Ганбаатар, Н.Сосорбурам, Ж.Сонинцэцэг, Б.Өлзийбаясагалан, М.Өлзиймөнх, С.Дэлгэрцэцэг, Б.Оюунцэцэг, Д.Баатархүү нар ажиллаж байсан. 2014 оноос тус хэлтсийн даргаар ажиллаж Б.Энхтуяа ажиллаж байна. Нягтлан бодогч Д.Баатархүү, Ч.Эрдэнэчимэг, Ж.Нэмэхбаяр, Э.Нандин-Эрдэнэ, кассын нярав С.Дагийсүрэн, орлогын нярав Б.Ариунжаргал, Т.Туяа, Наранцэцэг, Л.Энхжаргал, Д.Дашдэжид, сэлбэгийн нярав Нямцэрэн, Ж.Мөнхцэцэг, бүртгэлийн ажилтан А.Мөнх-Амгалан, хангамжийн инженер М.Түвдэндорж, шугам шалгагч Д.Энхцэцэг, Б.Ганзориг нарын бүрэлдэхүүнтэй ажиллаж байна. Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон холбогдох хууль журмыг баримтлан байгууллагын санхүү эдийн засгийн үйл ажиллагааг хянан явуулж санхүүгийн ил тод байдлыг хангана.

Мөнгөн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж, төрийн өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалт, зарцуулалтыг хариуцна. Ерөнхий данс хөтлөн мэдээ тайлан тэнцлийг цаг хугацаанд нь үнэн зөв боловсруулна. Байгууллагын аж ахуйн ба бусад байгууллагатай хийсэн гэрээний биелэлтэнд хяналт тавих, санхүү бүртгэлийн ажилтнуудын хөдөлмөр зохион байгуулалтыг хариуцна. Байгууллагын төсөв зардлын гүйцэтгэл, төсвийн төсөл болон төлөвлөгөө үйл ажиллагааг сайжруулах төсөл орлого, зарлагын төсөл боловсруулан ажиллаж байна. Сардаа 432.9 сая төгрөгийн орлогыг шугамын үйл ажиллагаанаас олохоор төлөвлөснөөс 446.6 сая төгрөгийг олж орлогын төлөвлөгөөг байгууллагын хэмжээнд 103,1 хувиар биелүүлэн ажилласан.

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн 132 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2014 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн А/788 тоот захирамжаар “Автобус-3” Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрыг татан буулгаж, “Зорчигч тээврийн нэгтгэл” Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын Гуравдугаар бааз болон нийтийн тээврийн үйлчилгээг Тэвээрлэлт, үйлчилгээний алба, Техник, технологийн алба, Санхүүгийн алба, Хүний нөөцийн алба гэсэн 4 албатай, бүтцээрээ 503 ажилтан ажиллагсадтай. 2014 оны 11 дүгээр сард тус нэгтгэлийн 2 дугаар баазаас 20 автобус, 40 жолооч, 40

мөнгө хураагч шилжин ирсэн. Нийтийн тээврийн үйлчилгээг 9 чиглэлд ажлын өдөр 87 гаралт, амралтын өдөр 66 гаралтайгаар Нийслэлийн иргэдэд үйлчилж байна.

Бүтээн байгуулалтын ажил: Тус байгууллагын барилга байгууламж 1954 онд байгуулагдсан хуучны байгууламж юм. Үе үеийн удирдлагууд байгууллагын бүтээн байгуулалтанд ихээхэн анхаарч ажиллаж ирсэн. 2004-2009 оны хооронд тус байгууллагын барилга байгууламжын 70%-аад хувийг түрээсийн байгууллагууд эзэмшин ажиллуулж байсан. 2009 оноос парк шинэчлэлт хийснээр байгууллагын үйлдвэрлэлийн зориулалттай барилга байгууламжыг буцаан авч сэргээн завсарлах ажлыг зохион байгуулан хийсэн. 2009 онд 120 сая төгрөгийн бүтээн босголтын ажил, 2010 онд 150 сая төгрөг, 2011 онд 194 сая төгрөг, 2012 оны гурав дугаар улиралын байдалаар 300 сая төгрөгийн бүтээн босголтын ажлыг хийж ажилтан албан хаагчдынхаа ажиллах нөхцөл бололцоог сайжруулсан. 2010 онд Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар, Авто тээврийн газраас хамтран зохион байгуулсан мэргэшсэн “Д” ангиллын жолооч бэлтгэх курс ажиллуулах төндэрт ялж сургалтын төвийг нээн ажиллуулаад 2 жил нүүрийг үзэж байна. Тус төвийг ажилуулснаар нийтийн зорчигч тээврийн үйлчилгээнд ажиллах 525 жолоочийг амжилттай бэлтгэн ажлын байраар хангаж ажилласан. 2011 онд Улиастайн эцсийн буудал дээр улиастайн төвийг нээж нийтийн тээвэрт ажиллаж буй жолооч, мөнгө хураагч нарын цайны газар, ариун цэвэрийн өрөө халуун усны асуудалыг шийдэж өгсөн. Уг төвийг нээснээр шинээр 8 хүнийг ажлын байраар ханган ажилласан. 2013 онд өөрийн хөрөнгөөр 400,0 сая төгрөгийн бүтээн байгуулалтын ажил хийхээр төлөвлөсөн. Ажилтан, ажиллагсдын ажиллах нөхцлийг сайжруулах үүднээс 12 өрөө тасалгаа, 1 ариун цэврийн өрөөнд урсгал засвар хийж, дотоод сүлжээг шинээр монтажлан, интернетийн орчинг сайжруулсан. Конторын 87 ширхэг цонхыг вакумжуулах ажилд 210738964 төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлыг тус тус хийсэн. Мөн засвар цехэд 8663,9 мянган төгрөгийн багаж хэрэгсэл, галын аюулгүй байдлыг хангах үүднээс 139,3 мянган төгрөгийн багаж хэрэгсэл худалдан авч ажлын байрны нөхцлийг сайжруулах ажлыг зохион байгуулсан.

Хоёр. Хөмрөгийн түүх

Тус байгууллага нь нийслэлийн Архивын газарт баримтаа шилжүүлэн байнга хадгалах нийт 126 хн баримтаар 133 дугаарт хөмрөг үүсгэсэн. Үүнээс хойшхи үйл ажиллагааны явцад үүссэн баримтыг байгууллагын архивт хадгалж байгаад төрийн архивт шилжүүлэх, нөхөн бүрдүүлэлт, ЭШТБ-н ажил гүйцэтгэх 2012 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн 2012/04 дүгээр гэрээний дагуу “Баримт бичиг шилжүүлэх акт”-аар нийслэлийн архивын газарт 1971-2010 оны 1509, хн дүрс бичлэгийн 2011 оны 6 DVD баримт шилжүүлсэн. Архивч, сэлбэн засагч О.Жүгдэрнамжил гэрээний дагуу Автобус-3 Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын 1509 хн хүлээн авч 2012 оны 10 дугаар сарын 03- ны өдрөөс 12 дугаар сарын 10-ны хооронд ЭШТБ-нын ажлыг хийж гүйцэтгэсэн. Нийслэлийн архивт хадгалагдаж байсан 126 баримтад дахин боловсруулалт хийсний үр дүнд байнга хадгалах 317 хн нэгж үдэж хавтаслан,

хуудас дугаарлан, хөмрөгт хадгалагдаж байсан 1964-2000 оны 126-н хн-д дахин боловсруулалт хийсэн шаардлагатай гэж үзсэн дансыг задлан бүртгэл үйлдэж 2001-2010 оны 191–н баримтад бүртгэл үйлдэн данс нэгтгэн ББНШАЗК-ын хурлаар хэлэлцүүлж батлуулсан.

Баримтыг цэгцлэх явцад:

➤ Хөмрөгт хадгалагдаж байсан 1528 –ээс 213хн-ийг задлан мэдээлэл лавлагааны ач холбогдолгүй, хугацаа дууссан баримтыг устгалд оруулсан. Заримыг нь нэр төрлөөр нь ангилан ялгаж дахин боловсруулалт хийсэн. Үүний үр дүнд 1999-2013 оны нийт 1528 хн-д ЭШТБ хийсэн.

➤ Түр хадгалах 1999-2013 оны 1192 хн-ийг оны зохион байгуулалтаар ангилан ялгаж, ач холбогдлоор нь дугаар өгч бүртгэл үйлдэн, хавтас солих шаардлагатай баримтын хавтасыг сольж, эмхлэн цэгцэлсэн бөгөөд хугацаа дууссан баримтыг устгалд оруулж түр хадгалах 1999-2013 оны 1192 хн-ийг байгууллагын архивт бүртгэл үйлдэж тавиурт байрлуулсан.

➤ Санхүүгийн тайлан баланс зэргийг хадгалах хугацаагаар нь ялган үдэж байнгад бүртгэн авсан.

➤ 2011 оноос эхлэн 4-р улирлын санхүүгийн баримтуудыг задлан байнга хадгалах болон 70 жил хадгалах баримтыг ялган авсан

➤ 70 жил хадгалах 1993-2013 оны 159 хн хугацаа дуусч задлагдсан санхүүгийн баримтаас цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн хуудсыг түүвэрлэн авч нийт 4 хн болгон байгууллагын архивт хадгалуулахаар бүртгэл үйлдсэн.

➤ 2002-2013 оны байнга хадгалах 56хн нэгж, тусгай төрлийн 3 хн-ийг оны зохион байгуулалтаар ангилан ялгаж, ач холбогдлоор нь дугаар өгч бүртгэл үйлдэн, хавтас солих шаардлагатай баримтын хавтасыг сольж, эмхлэн цэгцэлсэн.

➤ 2002- 2009 оны хугацаа дууссан 212 баримтыг устгалд оруулсан.

ТҮҮХЧИЛСЭН ЛАВЛАХ ҮЙЛДСЭН:

АРХИВ, БИЧИГ ХЭРГИЙН АЖИЛТАН

Л. ТУЛГА